

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 10 ны өдрийн

А /343 д у г а а р

з а х и р а м ж и й н 13

хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ**

д/д	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2022	Зорилтот түвшин тухайн жил	Хүрсэн түвшин	Хэрэгжилт тайлбар	Бай-ын үнэлгээ	ХШҮТ-ийн Үнэлгээ
1	Иргэд, ААН болон харилцагч бусад байгууллагаас гаргасан нийт хүсэлт, гомдлыг хуулийн хугацаанд бодитой шийдвэрлэсэн асуудлын эзлэх хувь	Тухайн онд иргэд, ААНБ-аас 9 өргөдөл. 2 хүсэлт ирсэн бөгөөд өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн.	Тайлангийн хугацаанд ирсэн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж барагдуулах	Тайлант хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд өөрийн хүсэлт, хувийн шалтгаанаар ажлаас чөлөөлөгдөх өргөдөл 1, хяналт шалгалттай холбогдуулан тэтгэмж нөхөн авах өргөдөл 1, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлгэх 1, байгууллагын ажилтнуудаас 5 хүсэлт нийт 8 өргөдөл, санал хүсэлт ирсэн байна. Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж хариуг хүргүүлж бүртгэлжүүлж ажиллалаа.		100%	
2	Төсвийн орлогыг бүрдүүлэлт /сая төг/	295400.0 мянган төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлсэн.		15985.4 мянган төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлэхээр акт тогтоосон байна.		100%	

3	Өмч ашиглалт хадгалалт. Худалдан авалтын үр дүн	Тайлант онд багаж техник хэрэгсэл зардлаас 4100.0 мянган төгрөг, тавилга эд хогшлын зардлаас 4000.0 мянган төгрөг, урсгал засварын зардлаас 9300 мянган төгрөг. Нийт 17400.0 мянган төгрөгийн худалдан авалт болон урсгал засварын зардалд зарцуулах.	10100.0 мянган төгрөгийн худалдан авалт хийх	Тайлант онд багаж техник хэрэгслийн зардлаас 10100.0 мянган төгрөгийн компьютер, принтер, скайнер, халаагуур зэрэг худалдан авч албан хаагчдад хариуцуулан эд хөрөнгийн картанд бүртгэсэн.	Албан хаагчдыг ажиллах нөхцөлөөр хангаж ажилласан байна.	100%	
4	Төсвийн хэмнэлт /хувь/	2022 онд 286400 мянган төгрөг батлагдаж 278500 мянган төгрөгийн санхүүжилт авч үүний 7400 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж батлагдсан төсвийн 3.8 хувийг хэмнэж ажилласан.		2023 онд 404369.9 мянган төгрөг төсөв батлагдаж 404369.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 403594.4 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч 775.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажиллаж. 0.2 хувийг хэмнэж ажилласан.		100%	
5	Цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийн талбай /мод бут, сөөгний тоо/	2022 онд Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд хаврын тариалалтаар 140 хайлаас, намрын тариалалтаар 90 улиас тариалсан.	Олгосон газарт 300 хайлаас, улиас мод тарьж ургуулах.	Өмнө онд 230 мод тарьсан 2023 онд хаврын тариалалтаар Ойжуулалт ХХК-аас 110 мод намрын тариалалтаар Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-аас 124 мод тус тус худалдан авч нөхөн тариалт хийсэн бөгөөд ургалт 84 хувь буюу 390 мод арчилж тордон тухайн үйл ажиллагааны тайланг Баруун-Урт сумын ЗДТГ хүргүүлэн ажиллаж байна.	Өмнө тариалсан мод болон шинээр тарьсан модоо усалж, зэрлэгийг цэвэрлэж, арчилж байна.	100%	

6	Хийгдсэн хяналт шалгалт, дотоод аудитын үр дүн	2022 оны жилийн эцэст төлөвлөгөөт хяналт шалгалт 40, төлөвлөгдөөгүй хяналт шалгалт 2 нийт 42 объектод санхүүгийн хяналт шалгалт, 32 объектод дотоод аудит хийж 187853.5 мянган төгрөгийн 36 салбар акт тогтоож, 1712250.7 мянган төгрөгийн 38 албан шаардлага үйлдэж, 86 зөвлөмж өгч хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	2023 оны жилийн эцэст нийт 35 объектод санхүүгийн хяналт шалгалт, 9 объектод дотоод аудит хийж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	2023 оны жилийн эцэст төлөвлөгөөт хяналт шалгалт 35, төлөвлөгдөөгүй хяналт шалгалт 2 нийт 37 объектод санхүүгийн хяналт шалгалт хийж, 15985.4 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн 20 акт тогтоож, 494173.5 мянган төгрөгийн 29 албан шаардлага үйлдэж, 9 объектод дотоод аудит хийж 45 зөвлөмж өгч хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.		100%	
7	Улсын /ахлах/ байцаагчийн акт албан шаардлага, торгууль шийтгэврийн барагдуулалт, биелэлт /тоо, үр дүн/	Өмнөх оны төлөгдөөгүй актын үлдэгдэл 400344.1 мянган төгрөгөөс 2022 онд 140978.7 мянган төгрөг, тайлант онд 187853.5 мянган төгрөгийн акт тогтоосноос тухайн онд 154491.0 мянган төгрөг, нийт 295469.7 мянган төгрөг төсвийн орлогод төвлөрсөн бөгөөд өмнөх оны актын биелэлт 35.2 хувь, тухайн оны актын биелэлт 82.2 хувьтай байна.	Хуулийн хэрэгжилтийг хангуулах	Хяналт шалгалтаар 510,158.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, 15,985.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр улсын ахлах байцаагчийн акт 494,173.5 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага тус тус тогтоов. Актын биелэлт 78%, албан шаардлага 85%-ийн барагдуулалттай байна. Шалгалтаар илэрч байгаа нийт зөрчлийн дийлэнх хувийг хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй, төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, зарцуулсан зөрчил тус тус эзэлж байна.	2022 оны үлдэгдэл 292727.9 мянган төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн. 2023 оны актын төлбөрийн 12468.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажилласан. 420047.4 мянган төгрөгийн зөрчлийг арилган ажилласан байна.	78%	
		Дундаж хувь				97%	

Биелэлт гаргасан:
Дотоод аудитор
Хянасан:
Албаны дарга

Б.Цэрэнпагам
Т.Цэрэгбаяр